

## **“Авлигагүй нийгэм-тогтвортой хөгжлийн гарц” Үндэсний бага хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч Намбарын Энхбаярын хэлсэн үг**

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нар аа!

Та бүхний түмэн амар амгаланг айлтгая!

Өнөөдөр та бид улс орныхоо ирээдүйн хөгжил дэвшилд нэн хамааралтай нэгэн чухал асуудлыг хэлэлцэхээр хуран цуглараад байна.

Энэ хурлын агуулга, ач холбогдлыг товчхондоо нэр нь илэрхийлж байгаа гэж хэлж болно.

Миний бие авлигатай тэмцэх энэхүү Үндэсний бага хурлыг өөрийн ивээл дор зохион байгуулж төрийн удирдлагын дээд түвшний албан тушаалтнууд, хувийн хэвшлийнхэн, иргэний нийгмийн оролцоотойгоор улс орны эрх ашиг ихээхэн шаардаж байгаа уг асуудлыг чуулан хэлэлцэж, үзэл бодол, хүсэл зоригоо илэрхийлэх арга хэмжээ болгон зохион байгуулж байгаа юм.

Юуны өмнө энэ үндэсний бага хурлыг зохион байгуулсан Авлигатай тэмцэх газар, түүнийг дэмжин оролцсон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн удирдлага, хамт олонд талархлаа илэрхийлье.

Улс төр, нийгэм, эдийн засаг, ер нь нийгмийн бүхий л салбарт хор хөнөөлөө тусгаж, уруудаж доройтохын шалтгааныг тарьдаг нийгмийн энэ аюулт үзэгдэл орчин үед ганц нэг улс орны бус, дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудал болжээ. Хүйтэн дайны үе дуусч, дэлхийн даяаршил эрч хүчээ авсан сүүлийн хориод жилд улс түмний харилцаанд урьд өмнө байгаагүй нэн таатай нөхцөл бүрдэж, хөгжил дэвшлийн сайхан боломж нээгдсэн хэдий ч түүнийг дагасан сөрөг үзэгдлүүд мөн даяарших болсны нэг нь авлига юм.

Энэ үзэгдэлтэй олон улсын хэмжээнд, дэлхийн хамтын нийгэмлэг хамтран тэмцэхээс өөр аргагүй байдалд хүрснийг харгалзан 2003 онд НҮБ-аас Авлигын эсрэг Конвенцийг батлан гаргасан билээ. Түүний удиртгал хэсэгт энэхүү Конвенцийг батлан гаргах болсон шалтгааныг хэд хэдэн зүйлээр тодорхойлсны дотор “Авлигын улмаас нийгмийн тогтвортой болон аюулгүй байдалд үүсч буй бэрхшээл, аюул занал нь ардчилсан тогтолцоо, үнэт зүйлс, түүнчлэн ёс зүйн үнэт зүйлс, шударга ёсыг сулруулж, тогтвортой хөгжил, хууль дээдлэх ёсонд хохирол учруулж байгаа”-г хамгийн эхэнд дурдсаныг анзаарахгүй байхын аргагүй юм.

Хэдийгээр авлигын нөхцөл байдал олон улсын хэмжээнд, ялангуяа социалист гэгдэж байсан ихэнх орнуудад төдийлөн таатай бус байгаа боловч энэ нь манай улсын хувьд тайвшрах, бусдыг харзсан хүлээх шалтгаан болох ёсгүй. Дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүнийхээ хувьд энэхүү тэмцэлд өөрийн хувь нэмрийг оруулж идэвхтэй байр сууринаас хандаж, эх орондоо ардчилал, шударга ёсны зөв тогтолцоог цаг алдалгүй цогцлоон бүрдүүлж, эрүүл саруул хөгжлийн гарцыг нээх нь бид бүхний амин чухал эрх ашиг мөн.

Олон улсын “Транспэрэнси интернэшнл” байгууллагаас жил бүр гаргадаг авлигын нөхцөл байдлын индексээр 2006 онд Монгол Улс авбал зохих 10 онооноос 2.8 оноотойгоор 99 дүгээр байрт оржээ. Өөр цаг хугацаанд, өөр хоорондоо ялгаатай байгууллага, багуудаас явуулсан судалгааны бүх үнэлгээ, дүгнэлтэд манай улсад авлигын нөхцөл байдал таагүй байгааг дурдсан байна. Ялангуяа эдгээр судалгааны хүрээнд явуулсан санал асуулгаар хүмүүсийн санааг хамгийн их зовоож байгаа асуудлуудын эхний хэсэгт авлигыг нэрлэсэн байгаа юм.

Сүүлийн жилүүдэд манай иргэд, олон нийт улс орондоо болж байгаа бараг сөрөг үзэгдэл болгоныг авлигатай холбож ярих, түүнийгээ ямар нэг хэлбэрээр илэрхийлж төр, засгийн анхааралд хүргэхийг эрмэлзэх хандлага давамгайлах

боллоо. Иргэдээс надад ирүүлдэг санал, хүсэлтүүдэд ч, уулзалт ярилцлагын үед ч эх орныхоо ирээдүйг авлигагүйгээр цогцлоон хөгжүүлэх нөхцлийг аль болох хурдан түргэн бүрдүүлэх талаар санаа тавин Төрийн тэргүүндээ хандах нь багасахгүй байна. Олон түмний маань мэдрэмж ортой, үндэстэй гэдгийг нийгмийн төрөл бүрийн асуудлуудаар зохион байгуулагдсан иргэний нийгмийн жагсаал цуглаануудын уриа шаардлагуудаас ч, хэвлэл мэдээллээр илэрхийлэгдэж байгаа хүмүүсийн үзэл бодлоос ч, удаа дараагийн олон улсын болон үндэсний хэмжээнд явуулсан судалгаа дүгнэлтээс ч төвөггүй ойлгож болохоор байна.

Манай улсын хувьд авлигатай тэмцэх талаар гар хумхин суугаагүйг 1996 онд Авлигын эсрэг хууль, 2002 онд Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг тус тус батлан гаргаж мөрдүүлснээс тод томруун харж болно. Мөн нийгмийн энэ сөрөг үзэгдэлтэй тэмцэх талаар шил шилээ дарсан олон тооны хурал, зөвлөлгөөн зохион байгуулагдсаныг ч та бид сайн мэднэ. Гэхдээ үр нөлөөг нь авсан арга хэмжээний тоо, хэлбэрээр нь бус түүний үр дүнгээр хэмжих ёстой гэдэг үүднээс харвал улс орны хэмжээний авлигын нөхцөл байдалд дорвитой өөрчлөлт гарсангүй. Хууль тогтоомжийн хэрэгжилт ч дутуу дулимаг байгааг иргэд шүүмжилж байна. Хууль, хяналтын байгууллагуудын шалгасан, шийдвэрлэсэн ажлын дүн мэдээ нийгэм дэх авлигын бодит нөхцөл байдалтай тэр болгон нийцэхгүй байна гэж бас шүүмжилж байна. Гэхдээ өмнөх үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандахын зэрэгцээ тэдгээр нь өнөөгийн хийх ажлын суурь туршлага болсныг ч бас мартаж болохгүй.

Авлигатай тэмцэх ажлын явц удаан, үр дүн муутай байгааг нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн уур амьсгал нь Авлигын эсрэг шинэ хуулийг батлан гаргах, үүгээр Авлигатай тэмцэх газар хэмээх уг асуудлаар дагнасан, хараат бус, бие даасан байгууллагыг байгуулах талаар үндэсний зөвшилцөлд хүргэсэн явдал юм. Улс төрийн намууд, олон нийтийн санал оролцоотойгоор энэхүү нэгдсэн шийдэлд хүрсэн учраас үүнийг би “үндэсний зөвшилцөл” гэж зориуд цохон тэмдэглэж байгаа юм. Одоо бид нэгэнт хамтран буй болгосон тогтолцоогоо тал талаас нь дэмжин зөв зохистой, үр нөлөөтэй ажиллуулах, хууль тогтоомжоо нэг мөр, хэлбэрэлтгүй дагаж мөрдөхөд өөрөөсөө шалтгаалах болгоныг бүх шатандаа хийх ёстой.

Мэдээжээр нийгмийг авлигын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, ард иргэдэд авлигыг үл тэвчих ёс суртахуунд хэвшүүлэх, авлигын гэмт явдлыг таслан зогсоох, илрүүлэн шийтгэх, авлигын үр үндсийг арилгахад Авлигатай тэмцэх газар гол үүрэг гүйцэтгэх болно. Өнөөдөр энэ байгууллага руу нийгмээрээ анхаарал хандуулж, дорвитой, үр нөлөөтэй, зөв зохистой үйл ажиллагаа явуулахыг хүсэн хүлээж байна. Энэ их итгэл найдварыг тус байгууллага дааж, өөрийн түүхэн үүргийг гүнзгий ухамсарлан, мэргэшлийн өндөр түвшинд ажиллаж аль болох богино хугацаанд үзэгдэж харагдахуйц үр дүнд хүрнэ гэж найдаж байна.

Авлигатай тэмцэх газар дангаараа авлигын эсрэг тэмцлийн бүхэл бүтэн тогтолцоо биш, харин уг тогтолцооны төв хэсэг нь байх болно. Авлигатай тэмцэх газар энэ талаар амжилт олсон, туршлага хуримтлуулсан улс орнуудын жишгээр авлигын нөхцөл байдал, түүнд илэрч байгаа арга хэлбэр, үндэснийхээ онцлогийг судалж тогтоосны үндсэн дээр ажлын хэтийн болон ойрын зорилтоо оновчтой тодорхойлж, үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрийг шинжлэх ухааны үндэслэлтэй, чамбай боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй. Тус байгууллага улс орны хэмжээнд авлигын эсрэг хийх тэмцлийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь зохицуулан уялдуулах, бүх нөөц боломжийг нэгтгэн зангидаж үр дүнд хүргэх ажлыг зохион байгуулах гол үүрэг хүлээсний хувьд үйл ажиллагаандаа байгууллага, иргэдийг татан оролцуулах, хамтран ажиллах, тэдний итгэлийг

хүлээхүйц арга барилыг сонгон хэрэглэх явдлыг юуны түрүүнд анхаарах нь чухал юм. Ялангуяа прокурор, цагдаа, улсын мэргэжлийн хяналтын, үндэсний аудитын зэрэг газруудтай бодлого чиглэлээ уялдуулан нягт хамтран ажиллах явдал үүнд онцгой үүрэгтэйг зориуд цохон тэмдэглэж байна. Түншлэлийн сайн харилцаа амжилтын сурвалж болж чадсан зарим орны туршлагыг хэрхэвч мартаж болохгүй.

Шинээр өрхөө татаж, үүдээ нээж байгаа энэ байгууллагыг улс төрийн өрсөлдөөний явцуу ашиг сонирхолд ашиглан хэн нэгний, эсхүл аль нэг улс төрийн хүчний эсрэг чиглүүлэхийг оролдсон, эсхүл энэ байгууллагын нэр хүндийг эхнээс нь унагаж, ач холбогдлыг нь бууруулах зорилго бүхий үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар ялган салгаж, хараат бус, бие даасан байдлаа хадгалан, зөвхөн нийгмийн сайн сайхан байдал, шударга ёсны эрх ашгийг ягштал баримталж ажиллах хэрэгтэй. Хэн ч, ямар ч хэлбэрээр энэ байгууллагын эрх хэмжээнд халдаж шахалт тулгалт үзүүлэх эрхгүй, ийм үйлдэл, үйл ажиллагаанд тус байгууллага хэрхэвч автах ёсгүй юм. Энэ байгууллагын ажиллах нөхцөл, бололцоог эрх зүйн болон эдийн засгийн талаас нь бүрэн бүрдүүлж хараахан амжаагүй байгааг энд бас шуудхан хэлэх хэрэгтэй юм.

Авлигатай тэмцэх газрын хараат бус байдлын баталгааг нь хангах, байгууллагын хувьд улам бэхжүүлэхэд шаардагдах арга хэмжээнүүдийг УИХ, Засгийн газраас аль болох богино хугацаанд авч шийдвэрлэх шаардлагатай байгааг анхааруулж байна.

Миний бие УИХ-ын ээлжит чуулганы нээлтэд үг хэлэхдээ ялангуяа төрийн албыг авлигаас ангид байлгах, түүний мэргэшсэн тогтвортой байдлыг хангах талаар удаа дараа цохон дурдаж байсныг та бүхэн тод томруун санаж байгаа. Авлигатай тэмцэх ажлыг төрийн алба оройлон тэргүүлэх нь гарцаагүй. Иймд төрийн албан хаагчид ёс зүйн шаардлагаа сахин биелүүлж, зөвхөн хууль ёсонд захирагдан төрийн албаны буюу олон нийтийн ашиг сонирхлын тусын тулд хоёргүй сэтгэлээр ажиллах эрх зүйн болон бусад нөхцөлийг бүрдүүлэх ажлыг алгуурлалгүй хийх хэрэгтэй. Төрийн албаны үйл ажиллагаа олон нийтэд ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй байх учиртай. Ингэж баймааж төр, олон түмний итгэлцлийн тэгш харилцааны үр соёолон дэлгэрч, нийгмийн ёс суртахуун эрүүлжин сайжрах болно.

Төр, засгийн бүх байгууллагууд Авлигатай тэмцэх газраас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг дэмжин орон нутагтаа, салбар бүртээ, байгууллага болгондоо, шатан шатандаа авлигатай хийх тэмцлийг үр ашигтай явуулж, авлигын шинжтэй үйлдэл гаргуулахгүй байх талаар урьд урьдынхаас илүү санаачилга, эрч хүчтэй ажиллахыг цаг үе шаардаж байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд нь бүрэн зөв гаргаж өгөхөөс гадна Авлигатай тэмцэх газраас өгсөн зөвлөмж, шаардлагыг биелүүлэх, өөрсдөө тодорхой санал, санаачилга гарган ажиллах зэрэг хамтын ажиллагааны олон хэлбэрүүдийг хослуулан хэрэгжүүлбэл зохино. Авлигагүй нийгмийн төлөө бүх нийтийн тэмцлээс ангид нэг ч байгууллага, албан хаагч байх ёсгүй. Бүх нөөц боломжийг нэгтгэсэн нийтийн жигд тэмцэл л үр дүнд хүрэх гол түлхүүр болно гэдгийг хаа хаанаа санаж ажиллах хэрэгтэй байна. Энэ ажил тодорхой цаг хугацаа, бас эр зоригийг шаардах нь гарцаагүй.

Манай улсад үйлчилж буй сонгуулийн систем, сонгуулийн хууль, улс төрийн намуудын үйл ажиллагаа нь авлига гарах нөхцөл, боломж, нүх сүвийг сайтар хаасан байх ёстой юм. Гэтэл үнэн хэрэг дээрээ улс төрийн намуудын санхүүжилтийн асуудал одоог хүртэл зохистой шийдвэрлэгдээгүй, ил тод биш байгаа. Сонгуулийн үед зарцуулах зардлыг нөхөн олох асуудал тодорхой бус хэвээр, энэ нь улс төрийн намууд, нэр дэвшигчид “хандивлагчид”-аас хэт

хамааралтай байх нөхцлийг бүрдүүлж байгаа, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоо хэт их хэвээр байгаа учир бизнес эрхлэгчид төрд шургалан орж, бизнесийн үйл ажиллагаанд төрийн албан тушаалын өндөрлөгөөс идэвхтэй оролцох гэж завдаж байгаа зэрэг нь авлигын байдлыг хүндрүүлж байна гэж хэлэхээс өөр аргагүй юм. Эдгээр асуудлыг цогцоор нь шийдвэрлэх талаар миний бие Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд улс төрийн намууд, УИХ, Засгийн газарт хандан санал бодлоо нэг бус удаа тодорхой илэрхийлсэн билээ.

Чөлөөт зах зээлийн эдийн засаг зонхилсон ардчилсан нийгэмд авлигын үзэгдлийг хувийн хэвшлийн салбараас ангид авч үзэх боломжгүй нь ойлгомжтой. Зарим судалгааны дүнгээс харахад манай бизнес эрхлэгчдийн 70 орчим хувь нь үйл ажиллагаагаа явуулахын тулд авлигад оролцсон гэж хариулсан нь анхаарал татаж байгаа юм.

Төрийн албанд эрх мэдэл, хувийн хэвшилд мөнгө хөрөнгө төвлөрдөг нь жам ёсны тогтолцоо мөн боловч дээрх тоо баримтаас үзэхэд хоёр салбарын эрэлт хэрэгцээгээ хангах арга хэрэгсэл нь зарим талаараа авлигатай холбоотой болсон байж болзошгүй байна. Ийм бохир арга нь эдийн засгийн зах зээлийн жам ёсны хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, шударга өрсөлдөөний зарчмыг зөрчин, зарим нэгэнд нь илт давуу байдал олж авах бололцоо олгодог нь гарцаагүй. Хамгийн наад захын жишээ гэхэд ихээхэн хэмжээний мөнгө хөрөнгө зарцуулагдах ажил үйлчилгээ, тендергүйгээр, өрсөлдөөнгүйгээр явуулах хуулийг саяхан УИХ батлан гаргаж, Засгийн газар энэ зарчмын дагуу ажиллаж байгаа нь авлигатай тэмцэх талаар урьд өмнө хүрсэн түвшингөөс ухралт болсон гэж олон улсын байгууллагууд үзэж, ил тод шүүмжилж байна.

Цаашид төр ба бизнесийн шударга харилцааг буй болгох, төрийн байгууллага ба хувийн хэвшлийн хооронд авлига үүсгэхгүй байх нэгэн чухал нөхцөл бол төрийн байгууллагаас хувийн хэвшлийн салбарт олгодог зөвшөөрөл, үзүүлдэг үйлчилгээний тоог цөөлөх, хүнд суртлыг арилгаж, үүнд зөвхөн албаны ашиг сонирхлын үүднээс ханддаг байх, бараа үйлчилгээг худалдан авах харилцааг олон нийтэд нээлттэй, ойлгомжтой, өрсөлдөөний зарчим дээр тулгуурлан, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан явуулдаг болгох явдал юм.

Нийгэмд хувийн хэвшлийн гүйцэтгэж буй үүрэгтэй холбоотойгоор авлигатай нийгмээрээ хамтран тэмцэхэд энэ салбарынхны оруулах хувь нэмэр асар их байх нь дамжиггүйг анхааруулъя. Манай эдийн засгийн хөгжлийн ихээхэн нөөц ч үүнээс хамааралтайг бас сануулъя.

Авлигагүй нийгмийг цогцлоон хөгжүүлэх гол баталгаа, энэ сөрөг үзэгдлээс ангид байх нэгэн дархлаа нь манай иргэдийн ухамсар, ёс суртахуунд бий. Иргэний нийгмийн зүгээс Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж, төрийн үйл ажиллагаанд хяналтаа өндөржүүлж, улам бүр бурууд нүд хурц болж байгааг ардчилсан ёс төлөвшиж байгаагийн илрэл гэж үзэж, миний бие дэмжиж байгаа. Иргэдийн идэвхтэй оролцоо, дэмжлэггүйгээр нийгмээ авлигаас цэвэрлэх үйл хэрэг амжилтад хүрэх боломжгүй. Гэхдээ авлигын эсрэг иргэдийн эх оронч сэдэлттэй тэмцлээс улс төрийн тодорхой зорилготой үйл ажиллагаа огт ангид гэдгийг хаа хаанаа анхаарч ажиллах нь цаашдын ажил үйлст бас тустай байх болно. Иргэдийг соён гэгээрүүлэх, авлигын гэмт явдлаас урьдчилан сэргийлэх үйлст Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл томоохон үүрэг гүйцэтгэнэ гэж итгэж байна.

Эх орныхоо ирээдүйн халаа, залуу үеийг сурган хүмүүжүүлэх эрхэм үүрэг хүлээсэн боловсролын салбарынхны талаар дурдахгүй өнгөрч боломгүй. Хүүхэд, залуусын маань цэвэр, эмзэг оюун ухаанд эрдэм номын үрийг суулгахаасаа гадна тэдний хүмүүжил, ёс суртахуун төлөвших үүр уурхай нь болдгоороо энэ салбар

онцлог бөгөөд авлигатай тэмцэх үйл хэрэгт томоохон үүрэг хүлээж оролцох нь гарцаагүй. Энэ салбарынхан юуны өмнө өөрсдөө шударга, зарчимч зан чанарын талаар үлгэр дуурайлтай, өв тэгш байх учиртай. Шударга ёсыг дээдлэх, авлигыг үл тэвчих зан чанарыг хүүхэд, залуучуудад боловсролын бүх шатанд зориудын хөтөлбөр, арга зүйд тулгуурлан олгох, итгэл үнэмшил болгох ажлыг чамбай зохион байгуулан явуулах хэрэгтэй.

Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд авлигын гэмт явдлын шалтгаан, нөхцлийг судалж тогтоох, энэ талаар эрдмийн ажил хийх, хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, мэргэжлийн болон нийтийн хэрэглээнд зориулсан бүтээл туурвих зэрэг ажлыг эрчимтэй хийж, авлигын эсрэг үйл ажиллагааны шинжлэх ухааны үндсийг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах шаардлага бий болж байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны үр нөлөө хэвлэл, мэдээллийн салбарынхнаас ихээхэн хамааралтай. Энэ салбарынхны нийтлэл, нэвтрүүлгийн оновчтой, шуурхай, бодитой мэдээлэлгүйгээр, ёс суртахууны дэмжлэггүйгээр уг тэмцэл үр дүнд хүрэхгүй нь ойлгомжтой. Ялангуяа авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих, түүнийг жигшин цээрлэх сэтгэл зүйн нөхцөл, ёс суртахууныг олон нийтэд төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх үйл хэрэгт хэвлэл, мэдээллийн хэрэгслийн байнгын, тасралтгүй оролцоо нэн чухал билээ. Иймд бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд авлигатай тэмцэх асуудалд анхаарлаа хандуулж, энэ асуудлаар бий болж байгаа тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг нь байж, идэвхтэй хамтран ажиллах шаардлагатай байгааг сануулъя. Ингэхдээ манай хэвлэл, мэдээллийн салбарынхан нийгмийг хамарсан өөр хоорондоо үл итгэлцэх, хардаж сэрдэх жихүүн уур амьсгалыг бүрдүүлэхээс сэрэмжилбэл зохино. Мөн элдэв зорилготой захиалгат гүтгэлэг, доромжлолын бохир аргаас татгалзан, сэтгүүл зүйн ёс зүйн шаардлагыг баримталж, нийгмийн оюун санаа, ёс суртахуунд амин дэм болох, үндэснийхээ эв нэгдлийг хичээх зорилтоосоо хазайхгүй байх учиртай. Авлигатай тэмцэх газраас “Авлигагүй нийгмийн төлөө” нийтлэл, сурвалжлагын уралдааныг нийт сэтгүүлчдийн дунд зарлан явуулж байгааг тус газар, хэвлэл мэдээллийн албаныхны хамтын ажиллагааны эхлэл хэмээн талархан дэмжиж байна.

НҮБ болон Дэлхийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Азийн сан зэрэг олон улсын байгууллагууд эх оронд маань өрнөж байгаа авлигын эсрэг үйл ажиллагааг эхнээс нь дэмжин оролцож, бодитой хувь нэмэр оруулж байгаад талархлаа илэрхийлж байна. Цаашид ч энэ хамтын ажиллагаа улам гүнзгийрэн өргөжинө гэдэгт эргэлзэхгүй байна. Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцид оролцогч улсынхаа хувьд олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлж, дэлхий нийтийн тэмцэлд өөрийн хувь нэмрийг оруулах талаар уйгагүй ажиллах болно. Энэхүү Конвенци нь олон улсын болон үндэсний хэмжээнд авлигатай тэмцэх эрх зүйн үндсийг тогтоож өгснөөрөө нэн чухал ач холбогдолтой бөгөөд тус гэрээнд нэгдэн орсон манай улсад авлигатай тэмцэх илүү таатай нөхцлийг бүрдүүлсэн чухал алхам болсон юм.

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нар аа!

Та бид Эх орныхоо эрчимтэй хөгжил дэвшлийн шийдвэрлэх шинэ үе шатанд тулж ирлээ. Хориодхон жилийн өмнөөс хоёр нийгмийн тогтолцооны ялгааг даван туулах ажил эхэлж байсан бол бид шилжилтийн энэ үеийн гол хүндийг хамтын хүчээр нугалан ардаа үлдээж чадлаа. Одоо Монгол Улс маань өвгөдөөс өвлүүлсэн энэ газар нутгийнхаа уудам орон зай, байгалийн асар их баялаг, дэлхийд зонхилж

байгаа хамгийн том зах зээлүүдтэй хаяа дэрлэн оршиж байгаа газар зүйн байршил, хамгийн гол нь ард түмнийхээ оюун билэг, авьяас чадварын дундаршгүй хүчин зүйл дээр тулгуурлан үсрэнгүй хөгжих тохироо бүрдээд байна.

Энэ боломжийг соргог, авхаалжтай ашиглан түүхэн их үйлсийг нийгмээрээ цаг алдахгүй, эрч хүчтэй, үр ашигтай гүйцэлдүүлж, бүтээн байгуулахад шударга ёс, үнэнч шулуун сэтгэл, чин зориг, эрмэлзэл хэзээ хэзээнээс илүү ус агаар мэт чухал боллоо. Авлигын хорт үзэгдлийг дадал зуршлаасаа таягдан хаяхгүй, хууль дээдлэх зарчмыг жинхэнэ ёсоор нь дагаж мөрдөхгүй, ёс зүйн шаардлагад нэг мөр захирагдахгүй, нийтийн эрх ашигт хоёргүй үнэнч сэтгэл гаргахгүй, төр, иргэний хиргүй тунгалаг итгэлцэл, түншлэлгүйгээр өмнөө тавьсан өндөр дээд зорилгоо биелүүлж чадахгүй.

Иймд улс орноо авлигаас ангижруулан, нийгмээрээ цэвэр тунгалаг, сэтгэл санаа амар амгалан, уур бухимдалгүй аж төрөх сайхан цагийг аль болох хурдан цогцлоон улсаа тогтвортой хөгжүүлж, ард түмнээ амаржуулан жаргаах үйлст бүх нийтээрээ эв зөийг хичээн, хамаг хүчээ нэгтгэн зүтгэж, хувь нэмрээ оруулахыг та бүхэнд уриалж байна.

“Авлигагүй нийгэм-Тогтвортой хөгжлийн гарц” сэдэвт Үндэсний бага хурлын ажиллагаанд амжилт хүсье. Улс оронд маань авлигагүй төр, шударга ёсны сайн үйлс дэлгэрэх болтугай.

Анхаарал хандуулсанд баярлалаа.